**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 10 сарын 08 өдөр Дугаар А/599 Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1.ХОАОНӨГ/201801061 дугаартай Буянт сумын Норжинхайрхан багийн цементбетон зам, гэрэлтүүлгийн ажлын 50 хувийн гүйцэтгэлийн ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Комиссын дарга: | Д.Энхболд – Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга |
| Гишүүд: | И.Гантогтох – Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах, цагдаагийн хошууч |
| | Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын авто замын улсын байцаагч |
| | М.Пүрэв – Буянт сумын Засаг дарга |
| | Б.Сонинтуяа – Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн |
| | Ч.Эрдэнэбат – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | Ц.Сувдаа – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн |

Zax A/599 Ch

02 02674

2.ХОАОНӨГ/201801061 дугаартай Буянт сумын Норжинхайрхан багийн цементбетон зам, гэрэлтүүлгийн ажлын 50 хувийн гүйцэтгэлийн ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Энхболд/ – д даалгасугай.

3.Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН

Zax A/599 Ch